



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/489

Улаанбаатар хот

「 Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
Тамгын газрын эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 13,500,000 /арван гурван сая таван зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Төмөрбаатар/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 13,500,000 /арван гурван сая таван зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Төмөрбаатар/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001224

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын
 даргын 2020 оны 09 дугаар сарын 30 өдрийн
 А/а дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ын шийдвэр
Нийтийн эзэмшлийн хөрөнгө											
1	Усан оргилуур /ЗДТГ-н урд талбай	10	ш	1	12,000,000	12,000,000	11,700,000	300,000	Өнгө үзэмж муудсан	актлах	устгах
2	Усан толио /ЗДТГ-ын дотор/	10	ш	1	1,500,000	1,500,000	1,462,500	37,500	Өнгө үзэмж муудсан	актлах	устгах
Нийтийн эзэмшлийн хөрөнгийн дүн				2	13,500,000	13,500,000	13,162,500	337,500			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				2	13,500,000	13,500,000	13,162,500	337,500			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө											
Актлах хөрөнгө				2	13,500,000	13,500,000	13,162,500	337,500			